

"Дэлгэрэнгүй мэдээлэл авах эх сурвалж:
Дотоод аудитор Б.Ганчимэг
Холбогдох утас: 94094050
Өрөөний дугаар: 420 тоот
Цахим хаяг: Ganchimeg@erdenetpp.mn

“ЭДЦС” ТӨХК-ИЙН ТУЗ-ИЙН ДЭРГЭДЭХ ДОТООД АУДИТОРЫН АЖЛЫН ТАЙЛАН /2025.08.31-ний байдлаар/

2025 онд холбогдох хууль, тогтоомж, Эрчим хүчний сайдын 2023 оны А/271 дүгээр тушаалаар баталсан Эрчим хүчний салбарт мөрдөх дотоод аудитын аргачлал, салбарын дотоод аудитын загварын ажлын баримт болон компанийн ТУЗ-ийн баталсан Дотоод аудиторын үйл ажиллагааны журмыг удирдлага болгон “ЭДЦС” ТӨХК-ийн дотоод дүрэм, журмын хүрээнд дотоод аудитыг зохион байгуулж ажиллалаа.

Нэг. Удирдлага зохион байгуулалтын ажлын талаар:

Дотоод аудиторын 2025 оны хийх ажлын төлөвлөгөөг боловсруулан Аудитын хороогоор хянуулан 2025 оны 3 дугаар сарын 25-ны өдрийн ТУЗ-ийн хурлаар хэлэлцэн баталсан.

Батлагдсан төлөвлөгөөний дагуу дотоод аудит хийх удирдамжийг Аудитын хорооны даргаар тухай бүр батлуулж, дотоод аудит хийж ажиллалаа.

Хоёр. 2025 оны төлөвлөгөөний явц, үйл ажиллагааны талаар:

Компанийн дүрэм журам, стандартын мөрдөлт, хууль тогтоомжийн хэрэгжилт, НББ-ийн үнэн зөв хөтлөлт, бодит байдалд аудит хийж дүгнэлт, зөвлөмж гарган компанийн үйл ажиллагааг сайжруулахад дэмжлэг үзүүлэх. Тус зорилтын хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

2025 оны ажлын төлөвлөгөөний хамрах хугацаа 2025 оны 04 дүгээр сараас 2026 оны 03 дугаар сар хүртэл.

№	Хамрах хүрээ	Дотоод аудит хийх ажлын чиглэл	Аудит хийх хугацаа	Биелэлтийн тухай (товч)
Аудит:				
1	СБЭЗХ, ДШС	Дулааны борлуулалтын орлогод 2025 оны 1-р улирлын байдлаар дотоод аудит хийх.	2025 оны 4 сар	2025.04.09-ний өдрийн батлагдсан удирдамжийн дагуу “Дулааны борлуулалтын орлогод 2025 оны 1-р улирлын байдлаар дотоод аудитыг хийж гүйцэтгэв. Аудитаар илэрсэн асуудлын бүртгэлийг 2025 оны 06 дугаар сарын 09-ний өдөр компанид хүргүүлсэн. Илэрсэн асуудлын бүртгэлийн тайлбарыг компаниас хугацаанд нь ирүүлээгүй ба тайлангийн төслийг бичиж Аудитын хороонд танилцуулсан.

2	ЗУХ, СБЭЗХ, ХААХ, ИА	Шилэн дансны тухай хууль, журмын дагуу компанийн мэдээллийг шилэн дансны нэгдсэн сайтад бүрэн оруулсан эсэхэд аудит хийх.	Хагас жил тутамд	2025.07.06-ны өдрийн батлагдсан удирдамжийн дагуу Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд 2025 оны эхний хагас жилийн байдлаар дотоод аудит хийв. Тус аудитаар илэрсэн асуудлын бүртгэлийг 2025 оны 08 дугаар сарын 26-ны өдөр компанид хүргүүлсэн. Компаниас тайлбарыг бүрэн ирүүлээгүй ба ирүүлсэн тайлбарыг хүлээн авч тайланг боловсруулав. Тайлангийн төслийг ТУЗ-ийн Аудитын хороонд танилцуулахаар хүргүүлсэн ба дараагийн ээлжид компанид хүргүүлэхээр төлөвлөн ажиллаж байна.
3	СБЭЗХ, ХААХ	2025 оны эхний хагас жилийн бараа материалын дансанд аудит хийх.	2025 оны 8, 9 сард	Аудит хийхээр удирдамжийг боловсруулан Аудитын хорооны даргад танилцуулахаар хүргүүлсэн. Удирдамж батлагдсаны дараа аудитыг хийж гүйцэтгэнэ.
4	Холбогдох нэгж	2024 оны дотоод аудитаар өгөгдсөн зөвлөмжийн биелэлтэд хяналт тавих.	Тухай бүр	2024 онд Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний гүйцэтгэлд 2024 оны 3-р улирлын байдлаар дотоод аудит хийсэн. Компани нь тус дотоод аудитаар 13 асуудлаар 22 зөвлөмжийн биелэлтийг 2025.03.31-ний байдлаар ирүүлэх байсан. 2025.08.27-ны өдөр ирүүлсэн зөвлөмжийн биелэлтийг ирүүлсэн ба түүнийг хянан үзэх, үнэлэх боломжгүй байсан учир 2025.09.03-ны өдөр дахин тайлагнаж ирүүлэхийг дотоод захидлаар 2025.09.27-ны өдөр хүргүүлсэн. Одоогийн байдлаар зөвлөмжийн биелэлтийг ирүүлээгүй байна. 2024 онд Гүйцэтгэх захирлын 2024 оны эхний 5 сарын сарын тушаал, түүний хэрэгжилтэд үнэлэлт дүгнэлт өгөхөөр дотоод аудит хийсэн. Аудитаар өгөгдсөн зөвлөмжийн биелэлтийг компаниас ирүүлсэн ба 10 зөвлөмжийн биелэлтийг бүрэн хэрэгжсэн, дутуу 2 зөвлөмжийн хэрэгжилтийг 2025.09.30-ны өдөр ирүүлэх тухай захидлыг хүргүүлсэн.
Сургалт хөгжүүлэлт:				
1	Монголын мэргэшсэн нягтлан бодогчийн институтээс зохион байгуулдаг “Нягтлан бодох бүртгэлийн мэргэшүүлэх” кредитийн зөрүү арилгах сургалтыг судалж, шалгалт өгөх.		2025 оны 2-5 сар	Монголын мэргэшсэн нягтлан бодогчийн институтээс зохион байгуулдаг “Нягтлан бодох бүртгэлийн мэргэшүүлэх” кредитийн зөрүү арилгах хичээлд суралцсан ба холбогдох шалгалтыг өгч гэрчилгээ авсан.

ТУЗ болон аудитын хорооноос өгсөн үүрэг даалгавар биелэлтийг хангаж, өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллалаа. Хөндлөнгийн хяналт шалгалтаар ирсэн багт дотоод аудиторын хийсэн ажлыг танилцуулж, шаардлагатай материалыг бэлтгэж өгсөн. Дээд газраас ирүүлсэн хариутай бичиг болон өгсөн үүрэг даалгаврыг хугацаанд нь хүргүүлж ажиллав.

ДОТООД АУДИТОР